



ХӨДӨЛМӨРИЙН
ЯАМ



БАРОМЕТРИЙН СУДАЛГАА 2015

Улаанбаатар хот

БАРОМЕТРИЙН СУДАЛГАА 2015

УЛААНБААТАР ХОТ

Тайланг хянасан:

ХЭҮСМҮТ-ийн ХССМГ-ын дэргэдэх Бодлого, арга зүйн зөвлөл

Хэвлэлд бэлтгэсэн:

Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газрын мэргэжилтэн
Г.Мягмардуулам

Мэдээллийг боловсруулсан:

Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газрын мэргэжилтэн
Г.Мягмардуулам, М.Уянга

Хэвлэсэн тоо: 300 хувь

Цаасны хэмжээ: B5

“Хөх Монгол принтинг” ХХК-д хэвлэв.

Улаанбаатар 2016 он

ГАРЧИГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	6
ӨМНӨХ ҮГ.....	7
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....	8
 БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
1.1 Судалгааны танилцуулга.....	12
1.2 Судалгааны түүвэрлэлт.....	13
1.3 Судалгааны мэдээлэл цуглуулалт болон боловсруулалт	18
 БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	19
 БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	
3.1 Судалгааны ерөнхий мэдээлэл.....	24
3.2 Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ	30
3.3 Ажиллах хүчний дутагдал	42
3.4 Мэдээллийн эх сурвалж.....	46
3.5 Ажил олгогчийн бэрхшээл.....	47
3.6 Өмнөх судалгааны үр дүнгийн харьцуулалт	48
 ДҮГНЭЛТ.....	53
ХАВСРАЛТ.....	55

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ААНБ, ажиллагчдын эзлэх хувь, салбараар	14
Хүснэгт 2. ААНБ-ийн тоо, ажилтны тооны бүлгээр, хувиар.....	15
Хүснэгт 3. ААНБ-д ажиллагчдын тоо, ажилтны тооны бүлгээр, хувиар.....	15
Хүснэгт 4. ААНБ-ын тоо, ажиллагчидтай холбоотой зарим статистик	16
Хүснэгт 5. Ньюманы хуваарилатын дагуух түүврийн хэмжээ.....	17
Хүснэгт 6. Түүврийн хэмжээ, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр.....	17
Хүснэгт 7. Ажиллах хүчиний зарим статистик үзүүлэлт, 2014	21
Хүснэгт 8. ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар	25
Хүснэгт 9. ААНБ-ын ажилтан, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар	26
Хүснэгт 10. Ажиллах хүчиний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбар, хугацаагаар	38
Хүснэгт 11. Ойрын нэг жилийн хугацааны ажиллах хүчиний эрэлт.....	39
Хүснэгт 12. Ажиллах хүчиний эрэлт, салбараар, шинэ болон сул ажлын байрны төрлөөр	40
Хүснэгт 13. Хэрэгцээтэй ажиллах хүч, ажил мэргэжлээр	41
Хүснэгт 14. Ажиллах хүчиний дутагдал, бүсээр, ажилтны тоо, хүйсээр, ААНБ-ын тоогоор	44
Хүснэгт 15. Ажиллах хүчиний дутагдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажилтны хүйсээр	44
Хүснэгт 16. Ажиллах хүчиний дутагдал, ажил мэргэжлээр	46
Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан ААНБ, ажилтны тооны бүлгээр	48
Хүснэгт 18. Ажил мэргэжлийн эрэлт, /оноор/	51

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт	9
Зураг 2. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт	20
Зураг 3. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт	20
Зураг 4. ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар	21
Зураг 5. Шинэ ажлын байранд зуучлагдан орсон иргэд өмнөх онтой харьцуулсан дүн	22
Зураг 6. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага	24
Зураг 7. Аж ахуйн нэгж, байгууллага, бус нутгаар	24
Зураг 8. ААНБ, өмчийн хэлбэр, байршил	27
Зураг 9. ААНБ, үйл ажиллагааны хэлбэр	28
Зураг 10. Ажилтны ажлын байрны хэлбэр, хүйсээр	28
Зураг 11. Байнгын ажилтны боловсролын түвшин, хүйс	29
Зураг 12. Түр ажилтны боловсролын түвшин, хүйс	29
Зураг 13. Ирэх нэг жилийн хугацаанд шинээр ажилтан авах ААНБ, бус нутгаар....	30
Зураг 14. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт	31
Зураг 15. Эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	32
Зураг 16. Сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	33
Зураг 17. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт	34
Зураг 18. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт, бус нутгаар	35
Зураг 19. Ажиллах хүчний эрэлт, өмчийн хэлбэрээр	36
Зураг 20. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр	37
Зураг 21. Сул ажлын байр бий болсон шалтгаан	37
Зураг 22. Зохих мэргжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бус нутгаар	42
Зураг 23. Ажиллах хүчний дутагдалд орсон ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	43
Зураг 24. Ажиллах хүчний дутагдал, байгууллагын өмчийн хэлбэр, хүйсээр	43
Зураг 25. Шинэ ажилтан авахад ашигласан мэдээллийн эх сурвалж	47
Зураг 26. Ажил олгогчийн бэрхшээл, шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл	48
Зураг 27. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт, салбараар	49
Зураг 28. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт, бус нутгаар	50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

YCX	Үндэсний статистикийн хороо
ХЭҮСМҮТ	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа, мэдээллийн үндэсний төв
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БРС	Бизнес регистрийн сан
ХАА	Хөдөө аж ахуй
ISIC	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилаалт
YAMAT	Үндэсний ажил мэргэжлийн ангилаал ба тодорхойлолт
ISCO	Мэргэжлийн ангиллын олон улсын стандарт
ХССМГ	Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газар
ААН	Аж ахуйн нэгж
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох барометрийн судалгааг 6 дах жилдээ хийж үр дүнгийн тайлан танилцуулж байна. Судалгааны үр дүн нь мэдээллийн төдийгүй бодлогын хэрэгцээнд чухал ач холбогдолтой мэдээллийн хэрэгсэл болдог.

Энэхүү судалгаа нь олон улсын аргачлалын дагуу ирэх нэг жилийн хугацаан дах хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажиллах хүчиний эрэлтийг тодорхойлж, холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд хийсэн тайлбар, дүгнэлтүүдийг агуулснаараа онцлог юм.

Бид Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэгт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудаас түүвэрлэн 2050 аж ахуйн нэгжийг хамруулан, төрийн удирдлага ба батлан хамгаалахын үйл ажиллагаа, ажиллах хүчиний хөдөлгөөн багатай олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбаруудаас бусад 18 салбарын хүрээнд судалгаа хийлээ.

Энэхүү судалгаагаар 2016 оны ажиллах хүчиний эрэлт хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, бус нутгийн байршилаар, ажил мэргэжил бүрээр тодорхойлон гаргасан болно.

Та бүхнийг судалгааны үр дүнгийн мэдээллтэй танилцан, үйл ажиллагаандaa ашиглан, санал бодлоо солилцож, зөвлөмж, шүүмж ирүүлж хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

ЗАХИРАЛ

С.ЧОЙНОРОВ

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Барометрийн судалгааны зорилго нь ирэх нэг жилийн хугацаанд /2016.01-2016.12/ хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ажиллах хүчний хэрэгцээг мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, газарзүйн байршилаар тодорхойлон гаргаж хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, боловсрол сургалтын байгууллагууд, бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангах явдал юм.


Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт 2050 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан. Энэ нь 2014 оны жилийн эцсийн байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 59843*ААНБ-ын 3.4 хувь болж байна. Нийт ААНБ-ын 63.7 хувь буюу 1306 аж ахуйн нэгж Улаанбаатар хотын, 744 ААНБ-ыг 21 аймаг, 89 сумдаас хамруулсан байна. Олон ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байр шинээр бий болох магадлал өндөртэй гэж үзсэн учраас 150-аас дээш ажиллагчидтай 420 ААНБ-ын жагсаалтыг тусгайлан сонгож оруулсан.

Судалгаанд хамрагдсан 2050 ААНБ-д 174.9 мянган ажилтан ажиллаж байгаа нь бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ААНБ-д ажиллаж буй 530.3 мянган ажилтны 33 хувь болж байна. Нийт ажилтны 163.2 мянга нь буюу 93.4 хувь нь байнгын, 11.6 мянга нь түр ажилтнууд байна. Байнгын ажилтнуудын дунд бакалавр, бүрэн дунд боловсролтой хамгийн олон буюу 65 хувьтай дүйцэх 105.9 мянган ажиллагчид байгаа юм. Түр ажилтнуудын 75 хувь нь бакалавраас доош түвшний буюу тусгай мэргэжлийн болон бүрэн дунд, бага боловсролтой иргэд байна.

Ирэх нэг жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан ААНБ-ын 40 хувь нь шинээр ажилтан авна гэж хариулсан байна. Бус нутгаар авч үзвэл зүүн бусийн аймгуудад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 54.9 хувь нь шинээр ажилтан авах төлөвлөгөөтэй байгаа бол бусад бүсүүдийн аймгууд тус бүрийн аж ахуйн нэгж, байгууллагуудын 40 гаруй хувь нь ажилтан авахаар төлөвлөсөн байна.

Ирэх нэг жилийн хугацаанд 80 гаруй мянган сүл болон шинэ ажлын байр бий болохоор байгаа нь хөдөлмөрийн зах зээлд өмнөх жилүүдтэй адил зерэг дүр зураг хадгалагдаж байна. Нийт ажиллах хүчний шинээр бий болж буй эрэлтийн 79 хувь буюу 63.4 мянга нь жилийн эхний хагаст, үлдсэн 21 хувь буюу 16.7 мянга нь сүүлийн хагас жилд тус бий болох төлөвлөтэй байна.

Зураг 1. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт /салбар, хугацаа, ажлын байрны хэлбэр, шинэ, сул ажлын байрны төрөл тус бүрээр/



Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар ирэх нэг жилийн хугацаанд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, ХАА зэрэг салбаруудад ажиллах хүчний эрэлт их байна. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдааны салбарт 24.5 мянган ажилтан, барилгын салбарт 11.4 мянган ажилтан, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.1 мянган ажилтан ажилд авахаар хүлээгдэж байна.

Ажил мэргэжлийн хувьд хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийн тархалт олон төрөл байгаа боловч бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга, ХАА, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбаруудад эрэлт их байх төлөв ажиглагдаж байна. Эрэлттэй ажил мэргэжлүүдийг өмнөх жилүүдийн судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд ижил төсөөтэй шинжүүд хадгалагдаж байна.

- Ажиллах хүчиний шингээлт ихтэй эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд урьдын адил хөдөлмөрийн зах зээл дэх эрэлттэй ажил мэргэжлүүдийг тодорхойлж байна.
- Эрэлт өндөртэй байгаа мэргэжлүүд дотор мэргэжлийн ур чадвар эзэмшсэн буюу богино хугацааны сургалтанд хамрагдан эзэмшиж болох мэргэжил, мэргэжлийн болон техникийн сургалтаар бэлтгэгддэг мэргэжлүүд зонхицж байна. Дээд боловсролоос илүү мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоогоор бэлтгэдэг мэргэжлүүдийн эрэлт өндөр байгаа нь өмнөх жилийн судалгааны үр дүнтэй ижил байна.

Барометрийн судалгааны чухал зорилтын нэг нь хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчиний дутагдлыг илрүүлэх явдал юм. Энэ удаагийн түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 16 хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс шинээр ажилтан авч чадаагүй буюу ажиллах хүчиний дутагдалд орсон байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаас ажиллах хүчиний дутагдал хамгийн их байсан нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар /27.3

хувь/, боловсруулах үйлдвэрлэл /18.4 хувь/, үйлчилгээний бусад үйл ажиллагаа /8.9 хувь/ зэрэг салбарууд байжээ.

Ажил олгогчдод шинээр ажилтан авах болон ажиллуулахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг тодруулахад хамгийн их тохиолддог бэрхшээлээ дараах байдлаар нэрлэжээ. Судалгаанд оролцсон нийт ажил олгогчдын 83.8 хувь нь ажилтан авахад хүндрэл бэрхшээл тулгарч байгаагүй гэсэн байна. Харин хүндрэл бэрхшээл тохиолддог гэж хариулсан ажил олгогчдын хувьд 28.1 хувь нь тусгай зөвшөөрөл, эрхтэй байх, 21.1 хувь нь ажлын туршлага дутмаг, 14.2 хувь нь боловсрол, мэргэжлийн түвшин ажлын байрны шаардлагад нийцэхгүй гэсэн бэрхшээлүүдийг дурьдсан байна. Мөн дээрх шалтгаанаас бусад буюу хувь хүний суурь хүмүүжил, төлөвшлөөс хамааралтай /ажилдаа хариуцлагагүй ханддаг, цалин голдог, тогтвортой суурьшилгүй/ шалтгааныг 10.2 хувь нь нэрлэсэн байна.

Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь мэргэжлийн хувьд нарийн мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин байхаас гадна ажлын хангалттай туршлагагүй байдал, хувь хүний төлөвшил, тогтвортой суурьшил, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна.

БҮЛЭГ 1

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



БҮЛЭГ 1. Судалгааны арга зүй, зохион байгуулалт

1.1. Судалгааны танилцуулга

ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн богино болон урт хугацааны төлөв байдлыг судлах, хэтийн тооцоо боловсруулах" заалтыг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа мэдээллийн үндэсний төвийн Хөдөлмөрийн яаманд нийлүүлэх тусгай захиалгат бүтээгдэхүүн болох "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа хийх" ажлуудыг үндэслэл болгов.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны зорилго нь ирэх нэг жилийн хугацаанд /2016.01-2016.12/ хөдөлмөрийн зах зээлд хэрэгцээтэй байх ажиллах хүчиний мэргэжил, салбар, байршил бүрээр тодорхойлон, боловсрол сургалтын, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч байгууллагууд, бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангахад оршино.

ЗОРИЛТ

Энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчиний хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, ажил мэргэжил, аймаг, дүүргийн байршил тус бүрээр тодорхойлох
- Өнгөрсөн нэг жилийн хугацааны дотоодын хөдөлмөрийн зах зээлдэх ажиллах хүчиний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил тус бүрээр тодорхойлох
- Судалгааны үр дүнгээр тайлан бичих

АЖЛЫН АГУУЛГА

Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн эрэлтийн чиг хандлагыг тодорхойлох ажлын хүрээнд дараах мэдээллийг бий болгохыг зорилоо.

- Хэрэгцээт ажиллах хүчиний тоо, мэргэжил бүрээр /YAMAT-2008/
- Хэрэгцээт ажиллах хүчиний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар /ISIC/
- Хэрэгцээт ажиллах хүчин, ажлын байрны хэлбэрээр /байнгын болон түр/
- Хэрэгцээт ажиллах хүчиний тоо, ажил олгогч бүрээр

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ БАЙДАЛ

Уг судалгаа дараах хязгаарлалтуудыг өөртөө агуулсан болно. Үүнд:

1. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоог ашигласан учраас албан бус секторын хөдөлмөрийн эрэлтийг судлах зорилт тавигдаагүй.
2. 2014 оны жилийн эцэст үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоонд үндэслэсэн учир 2015 онд шинээр үйл ажиллагаа эрхэлсэн аж ахуйн нэгж байгууллагууд судалгааны хүрээнд багтаагүй болно.
3. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалалын салбарыг тус тус түүврийн хүрээнээс хасч тооцсон болно.

СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц нь ААНБ-уудын удирдлагатай уулзаж, ярилцлага хийх замаар судалгааны мэдээлэл цуглуулах ажлуудыг гүйцэтгэсэн. Судалгааны баг дараах зарчмуудыг баримтлан ажилласан. Үүнд:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн арга зүйг ашиглах
- Судалгааны оролцогчдын мэдээллийн нууцлалыг хамгаалах
- Бүх ойлголт, тодорхойлолтууд нь оролцогч талуудад /тухайлбал, асуулга боловсруулагчид, ярилцлага авагчид, судалгаанд оролцогчид, мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнууд/ ойлгомжтой байх.
- Цуглуулсан мэдээлэл нь судалгааны зорилгод нийцтэй, үнэн бодитой байх
- Судалгааны үр дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, хэрэгцээтэй байх

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2015 оны 8 дугаар сарын 17-наас 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Судалгаанд БРС-д бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудыг хамруулав. Судалгаанд хамрагдах үндсэн нэгжийн тоо нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, орон нутгийн 21 аймгаас сонгогдсон 2050 ААНБ юм.

1.2. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Судалгааны хүрээ:

Монгол Улсын хэмжээнд 2014 оны жилийн эцэст бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоогоор судалгааны хүрээг тодорхойлж авч үзсэн. 2014 оны эцэст 113.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 59.8 мянга буюу 52.7 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Улмаар бизнес регистрийн сангийн бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 59.8 мянган аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг судалгааны түүврийн хүрээ болгон ашигласан.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй 2014 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан нийт 59.8 мянганаж ахуйн нэгж байгууллагын 36.7 хувь, ажиллагчдын тооны 13.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт ногдож байна. Түүнчлэн төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны гурван салбарт нийт ААН-ийн 10.3 хувь, нийт ажиллагчдын 29.8 хувь ногдож байна.

Хүснэгт 1. ААНБ, ажиллагчдын эзлэх хувь, салбараар

ID	Салбарын нэр	ААН-ийн эзлэх хувь	Ажиллагчдын эзлэх хувь
A	ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5.6	2.8
B	Уул уурхай, олборлолт	1.5	6.3
C	Боловсруулах үйлдвэрлэл	7.7	9.6
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.4	2.8
E	Ус хангамж: Бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.3	1.0
F	Барилга	8.0	8.8
G	Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклийн засвар үйлчилгээ	36.7	13.9
H	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.9	5.4
I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3.4	2.9
J	Мэдээлэл, холбоо	2.1	2.5
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.7	2.5
L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.3	0.8
M	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6.1	3.4
N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.6	2.7
O	Төрийн удирдлага ба батлан хамгаалахын үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.4	8.5
P	Боловсрол	4.7	14.8
Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.2	6.5
R	Урлаг, զзвэр, тоглоом наадам	1.3	1.4
S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6.2	3.4
U	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.04	0.03
НИЙТ		100.0	100.0

Түүврийн хэмжээ:

Аж ахуйн нэгжид суурилсан түүвэр судалгааны хувьд аж ахуйн нэгж, байгууллагын хүчин чадал, эзлэх байр суурь, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийн стандарт хэлбэлзэл –/ерөнхий дүнгийн хувьд/ харьцангуй өндөр байдгаас шалтгаалан ойролцоо шинж чанараар бүлэглэж тодорхой хэсгүүдэд ангилдаг. Дараа нь бүлэг хэсэг тус бүрт нь харилцан адилгүй ногдох түүврийн хувь хэмжээг тогтооно.

Судалгаанд хамруулах аж ахуйн нэгж байгууллагын тоо буюу түүврийн хэмжээг тодорхойлоходоо дараах алхмын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Түлхүүр үзүүлэлтийг тодорхойлох – Ажиллагчдын тоо
2. Түлхүүр үзүүлэлтэд үндэслэн эх олонлогийг тодорхой интервалтайгаар бага,

- дунд, их бүлгүүдэд хуваарилах /Шинж чанараар нь буюу ажиллагчдын тооны их, багаар ялган нийт 5 бүлэг/
3. Ажиллагчдын хувийн жин хамгийн өндөр бүлгийн аж ахуйн нэгж байгууллагудыг 100 хувь судалгаанд хамруулах
 4. Үлдсэн аж ахуйн нэгж байгууллагын тоонд шаардлагатай түүврийн хэмжээг тогтоох
 5. Түүврийн хэмжээг Ньюманы тархалтаар хуваарилах
 6. Бүлэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар аж ахуйн нэгж байгууллагудыг сонгох

ААНБ-ын ажиллагчдын дундаж тооны интервалаар дараах бүлгийг үүсгэж, бүлгийн дагуу түүврийн хүрээг хувааж үзвэл дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 2. ААНБ-ийн тоо, ажилтны тооны бүлгээр, хувиар

Бүлэг	Ажиллагчдын тооны интервал	ААН-ийн тоо, мянга	ААН-ийн эзлэх хувь
1	1-5	47.1	78.7
2	6-19	7.8	13.0
3	20-49	3.1	5.2
4	50-149	1.4	2.3
5	150+	0.4	0.7
Дүн		59.8	100.0

Дээрх хүснэгтийн үр дүнгээс харахад 150, түүнээс дээш тооны ажилтантай байгууллага нийт ААНБ-ын 0.7 хувь ногдож байна. Харин 5 хүртэлх ажиллагчидтай байгууллагын тоо 47.1 мянга буюу 78.7 хувьтай байна.

Харин дээрх үүсгэсэн бүлгийн дагуу ажиллагчдын тоог авч үзвэл, 150, түүнээс дээш тооны ажиллагчидтай ААНБ-д нийт ажиллагчдын 31.2 хувь, 50-149 ажиллагчидтай ААНБ-д 21.2 хувь, 20-49 ажиллагчидтай ААНБ-д 17.4 хувь, 6-19 ажиллагчидтай ААНБ-д 15.2 хувь, 1-5 ажиллагчидтай ААНБ-д 15.1 хувь тус тус ногдож байна.

Хүснэгт 3. ААНБ-д ажиллагчдын тоо, ажилтны тооны бүлгээр, хувиар

Бүлэг	Ажиллагчдын тооны интервал	Ажиллагчдын тоо, мян хүн	Дүнд эзлэх хувь
1	1-5	79.9	15.1
2	6-19	80.5	15.2
3	20-49	92.4	17.4
4	50-149	112.2	21.2
5	150+	165.3	31.2
Дүн		530.3	100.0

Дээрх хүснэгтийн үр дүнгүүдээс харахад 150, түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн тоо 420 бөгөөд нийт ажиллагчдын тооны 31.2 хувь ногдож байна. Иймд тус бүлэгт түүвэрлэлт хийхгүйгээр 100 хувь (cut-off point) судалгаанд хамруулна.

Ингээд нэлэнхүйгээр авах 420 ААНБ-ыг хассаны дараа үлдсэн аж ахуйн нэгж байгууллагыг ажиллагчдын тооны бүлгийн хувьд харьцангуйгаар хэвийн тархалттай гэж үзэн түүврийн хэмжээг тогтоох хэрэгтэй болно.

Энд $59843 - 420 = 59423$ гэсэн эх олонлогоос судалгаа авах түүврийн хэмжээг тодорхойлно.

Түүврийн хэмжээг дараах томьёогоор тооцно.

$$n_{SRS} = \left(\frac{z_{\alpha/2} \cdot S}{e} \right)^2 \quad (1)$$

Бид үлдсэн бүлгүүдийн түвшинд эх олонлогийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоход доорх үр дүн гарсан.

Хүснэгт 4. ААНБ-ын тоо, ажиллагчдтай холбоотой зарим статистик

№	ААН-ийн тоо, мянга	Ажиллагчдын тоо, мянга	Ажиллагчдын тоо /дундаж/	StdDev of Ажиллагчдын тоо
1	47.1	79.9	1.7	1.1
2	7.8	80.5	10.4	3.8
3	3.1	92.4	29.5	8.2
4	1.4	112.2	79.9	25.6
Нийт	59.4	365.0	6.1	14.0

Практикт 95 хувийн ач холбогдлын түвшинг ихэвчлэн авч үздэг бөгөөд энэ үед т статистикийн утга 1.96 гэсэн утгыг авдаг. Нөгөөтэйгүүр бид өгөгдсөн бүлгийн түвшинд эх олонлогийн дундаж болон стандарт хазайлтыг тооцоход дээрх үр дүн гарсан.

Харьцангуй алдааг 10 хувь байна гэж үзвэл бидний таамаглаж байгаа түүврийн алдааны хязгаар $e=0.10 * \text{average Ajillagchid}=0.10 * 6.1=0.61$ болно.

Харин эх олонлогийн стандарт хазайлт $S=14.04$ байна. Одоо тус утгуудыг түүврийн томьёонд орлуулан тооцье.

$$n_{SRS} = \left(\frac{z_{\alpha/2} * S}{e} \right)^2 = \left(\frac{1.96 * 14.94}{0.61} \right)^2 = 2008$$

$$n = \frac{n_{SRS}}{1 + \frac{n_{SRS}}{N}} \quad (2)$$

Хэрвээ N буюу эх олонлогийн хэмжээг харьцангуй бага гэж үзвэл (2) томьёоны дагуу шинэчлэн тооцож болно.

Улмаар $n = \frac{2008}{1 + \frac{2008}{59423}} = 1943$ болно.

Ингээд бидний түүврийн эцсийн хэмжээ

$$n(f)=420+1943=2363.$$

Томоохон буюу ажиллагчдын тоо (150, түүнээс дээш) ихтэй аж ахуйн нэгж байгууллагуудыг шууд судалгаанд хамруулахаар сонгосны дараа 1943 аж ахуйн нэгж байгууллагыг оновчтой хуваарилалтын арга буюу Ньюманы хуваарилалтын аргаар ажиллагчдын тооны бүлгүүдэд хуваарилсан.

Хүснэгт 5. Ньюманы хуваарилалтын дагуух түүврийн хэмжээ

(1)	(2)	(3)	(4)	(5)
Бүлэг	Nh	Sh	Nh*Sh	Neuman - n(h)
1	47.1	1.14	53.9	724
2	7.8	3.75	29.2	392
3	3.1	8.18	25.6	344
4	1.4	25.56	35.9	482
	59.4		144.6	1943

Ийнхүү ажиллагчдын тооны бүлгүүдэд түүврийн хэмжээг хуваарилсаны дараа, бүлэг тус бүрээс энгийн санамсаргүй түүврийн аргаар харгалзах аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгож судалгаанд хамрууллаа. Ингэхдээ судалгааны үр дүнгийн хүснэгтийн гол задаргаа нь салбар байх учир салбарын хувьд харьцаангуй тэгш хуваарилалт буюу нэг салбарын хувьд ойролцоогоор 120-130 тооны ААНБ байхаар ажиллагчдын тооны бүлгийн хуваарилалттай хосломол болгон үүсгэсэн.

Хүснэгт 6. Түүврийн хэмжээ, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр

Код	Салбарын нэр	Ажиллагчдын тооны бүлэг					Дүн
		1	2	3	4	5	
A	ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	52	25	25	14	4	120
B	Уул уурхай, олборлолт	30	15	15	20	40	120
C	Боловсруулах үйлдвэрлэл	34	15	15	20	46	130
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	33	20	18	27	22	120
E	Ус хангамж: Нохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	36	24	28	28	4	120
F	Барилга	30	15	15	21	39	120
G	Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	40	15	15	20	43	133
H	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	35	16	16	30	23	120
I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	42	20	20	29	9	120
J	Мэдээлэл, холбоо	40	20	20	26	14	120
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	45	30	23	14	8	120

L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	45	35	27	11	2	120
M	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	46	20	15	30	9	120
N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	34	24	15	38	8	119
P	Боловсрол	22	15	15	20	48	120
Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	30	15	15	27	45	132
R	Урлаг, үзвэр, тоглоом наадам	30	20	35	33	3	121
S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	50	28	20	29	3	130
	Нийт	674	372	352	437	370	2205

Ингэж хуваарилалт хийхдээ Төрийн удирдлага ба батлан хамгаалахын үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбар, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарыг тус тус түүврээс хасч түүврийн хэмжээг 2205ААНБ байхаар болголоо.

1.3. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ БОЛОН БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл цуглуулалт

Энэ удаагийн судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг асуулгын хуудсыг таниулсан тусгай програм бүхий таблет ашиглан хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулалтанд таблет ашигласнаар шивэлт хийх шаардлагагүй бөгөөд үр дүн нь цаг хугацаа хэмнэх, шивэлтийн техник алдаа гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлж өгдөг давуу талтай юм. Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг 21 аймаг 9 дүүрэг, 80 гаруй сумдад хийсэн бөгөөд судлаачид очиж ажиллав.

Судалгааны асуулгын хуудас нь агуулгын хувьд дараах үндсэн 2 хэсэгт хуваагдана.
Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий мэдээлэл
2. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчиний эрэлтийн мэдээллийг тодруулах бүлэг хэсэг болно.

Асуулгын бүтэц нь өмнөх жилүүдэд хийгдсэн барометрийн судалгааны асуулгатай адил бөгөөд асуулгын стандарт, асуулгын код, хариултын дараалал, логик уялдаа зэргийг сайтар хангасан.

Мэдээллийн чанарыг хангах үүднээс мэдээллийн санд хяналтыг тогтмол явуулж, мэдээлэл цуглуулах явцад хийгдсэн ярилцлагын аудио бичлэгтэй тулгалт хийж, хариултын уялдаа холбоог шалган шаардлагатай тохиолдолд судалгаанд оролцогчоос тодруулан засварлан баталгаажуулах ажлыг хийв.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээлэл цуглуулалтыг таблетын тусlamжтайгаар хийж гүйцэтгэсэн учир судалганы мэдээлэл бүрэн электрон хэлбэрээр үүсч нэгтгэгдсэн. Мэдээллийн санг боловсруулалтад бэлтгэн хоёртын тооллын системд хөрвүүлсний дараа үр дүнгийн шинжилгээ хийх болон нэгдсэн хүснэгт, үр дүн гаргах боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

БҮЛЭГ 2


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



БҮЛЭГ 2. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал


Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш эдийн засгийн болон ажиллах хүчний бүтцэд томоохон дэвшил гарсан. 2014 оны статистик мэдээллээр 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 62.1 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байгаа ба тэдгээрийн 92.1 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна. 2014 оны жилийн эцсээр улсын хэмжээнд 95,9 мянган ажилгүй иргэн байгаагийн 37,0 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд буюу ажил идэвхитэй хайж байгаа иргэд байна.

Зураг 2. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт /хэмжих нэгж: мян.хүн/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 3. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлт /хэмжих нэгж: хувь/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл 39.0 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 8.2 хувь нь барилгын салбарт, 8.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн

салбарт, 10.4 хувь нь үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарт, 8.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 5.8 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт, 3.9 хувь нь тээвэр, агуулахын салбарт, 4.6 хувь нь боловсрол, 5.0 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 3.5 хувь нь зочид буудал, зоогийн газрын салбарт тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. ААНБ, Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар/хэмжих нэгж: хувь/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 7. Ажиллах хүчиний зарим статистик үзүүлэлт, 2014 он /хэмжих нэгж: хувь, мян. Хүн/


Бүс нутаг	Эдийн засгийн идэвхтэй хүн ам	Хувь	Ажиллагч-дын тоо	Хувь	Ажилгүй иргэд	Хувь
Бүгд	1206.6	100.0%	1110.7	100.0%	95.9	100.0%
Баруун бүс	178.2	14.8%	154.5	13.9%	23.6	24.7%
Хангайн бүс	260.9	21.6%	243.1	21.9%	17.7	18.5%
Төвийн бүс	202.8	16.8%	184.3	16.6%	18.6	19.4%
Зүүн бүс	88.5	7.3%	76.9	6.9%	11.6	12.1%
Улаанбаатар	476.1	39.5%	451.8	40.7%	24.3	25.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажил хөдөлмөр эрхэлж буй нийт ажиллагчдын 39.5 хувь нь Улаанбаатарт, 60.5 хувь нь орон нутагт ажиллаж байгаа ба төвийн бүс, хангайн бүс, Улаанбаатарт нийт ажиллагчдын 77.9 хувь нь харьялагдаж байгаа нь ажиллагчдын төвлөрөл нь төвөө дагаж байгааг илтгэж байна.

2014 оны эцсийн байдлаар Улсын хэмжээнд нийт 95.9 мянган ажилгүй иргэн байгаа ба тухайн жилд хөдөлмөрийн зах зээлд бий болсон шинэ ажлын байранд 52.3 мянган иргэн, 2015 оны 11 дүгээр сарын байдлаар 42.6 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг 5. Шинэ ажлын байранд зуучлагдан орсон иргэд өмнөх онтой /11сарын байдлаар/ харьцуулсан дун / хэмжих нэгж: тоо. мянган/хүн/



Эх сурвалж: ХЭҮСМҮТ

Ажлын шинэ байранд зуучлагдан иргэдийг өмнөх онтой харьцуулж харвал уул уурхай, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбаруудад зуучлагдан орсон иргэдийн тоо буурсан байна.

2014 онд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг 18.6 мянга, их, дээд сургууль, коллежийг 35.2 мянган оюутан төгсж хөдөлмөрийн зах зээлд 53.8 мянган мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэгдэж гарсан байна.

БҮЛЭГ 3

СУДАЛГААНЫ ҮР ДҮН



БҮЛЭГ 3. Судалгааны үр дүн

3.1 СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ удаагийн хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт 2050 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулаа.

ЗУРАГ 6. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага/хэмжих нэгж: тоо/



Аж ахуйн нэгж байгууллагын 63.7 хувь нь буюу 1306 аж ахуйн нэгжийг Улаанбаатар хотоос, 744 аж ахуйн нэгж, байгууллагыг 21 аймгаас буюу орон нутгаас хамруулсан байна.

Зураг 7. Аж ахуйн нэгж, байгууллага, бус нутгаар/хэмжих нэгж: хувь/



Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын 63.7 хувь нь Улаанбаатар хотод, 4.6 хувь нь зүүн бүсэд, 12.6 хувь нь төвийн бүсэд, 11.0 хувь нь хангайн бүсэд, 8.0 хувь нь баруун бүсэд үйл ажиллагаа явуулж байна. Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 87.3 хувь нь Монгол улсын төв хэсэгт үйл ажиллагаа явуулж байгаа нь хүн амын төвлөрлийг даган ААНБ-ууд үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна.

Хүснэгт 8. ААНБ, Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар

/хэмжих нэгж: тоо, хувь/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажилтны тоогоор	ААНБ-ын тоо		
	Судалгаанд хамрагдсан ААНБ	Хувь	ААНБ-ын тоо ¹
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	113	3.3%	3380
Уул уурхай, олборлолт	86	9.9%	871
Боловсруулах үйлдвэрлэл	125	2.7%	4580
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	92	43.4%	212
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	84	48.6%	173
Барилга	154	3.2%	4763
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	264	1.2%	21952
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	97	8.5%	1137
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	93	4.6%	2028
Мэдээлэл, холбоо	79	6.2%	1273
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	100	6.2%	1608
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	50	6.6%	763
Мэргэжлийн, шинхлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	117	3.2%	3632
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	142	5.2%	2746
Боловсрол	137	4.8%	2826
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	146	7.6%	1915
Урлаг, үзвэр, тоглоом наадам	93	11.7%	797
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	78	2.1%	3726
Нийт	2050	3.5%	58382

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Энэхүү судалгаанд 2050 ААНБ хамрагдсан нь 2014 оны жилийн эцсийн байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй/судалгааны түүвэрт хамрагдсан эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын хувьд/ 58382 ААНБ-ын 3.5 хувь болж байна.

¹ Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо

Эх олонлогт эзлэх хувиар өндөр хамрагдалтыг харуулж буй салбарууд нь цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж /43.4хувь/, усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны /48.6 хувь/ салбарууд байна. Энэ нь тус салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-үүд олон ажилтантай байдаг учраас 150 болон түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийг нэг бүрчлэн хамруулсантай холбоотой юм. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-үүдүн 9.9 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын ААНБ-ын 8.5 хувь урлаг, үзвэр, тоглоом наадам гэсэн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 11.7 хувь нь тус тус судалгаанд хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан 2050 ААНБ-д 174.9 мянган ажилтан ажиллаж байгаа нь бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 58.4 ААНБ-д ажиллаж буй 485.0 мянган ажилтны 36.1 хувийг эзэлж байгаа юм.


Хүснэгт 9. ААНБ-ын ажилтан, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар
/хэмжих нэгж: мян.хүн, хувь/

Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар	Ажилтны тоо	
	Судалгаанд хамрагдсан ААНБ-д ажиллаж буй	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2425	1.4
Уул уурхай, олборлолт	13954	8.0
Боловсруулах үйлдвэрлэл	12038	6.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	10706	6.1
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	7796	4.5
Барилга	8755	5.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	14681	8.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	9157	5.2
Байр, сууц болон хуол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3716	2.1
Мэдээлэл, холбоо	22368	12.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	8427	4.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5002	2.9
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12371	7.1
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4961	2.8
Боловсрол	13581	7.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	19636	11.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	3403	1.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1887	1.1
Нийт	174864	100.0

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл судалгаанд хамрагдсан ААНБ-уудын хувьд мэдээлэл холбооны салбарт 12.8 хувь буюу 22.4 мянга, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 11.2 хувь буюу 19.6 мянга, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 8.4 хувь буюу 14.7 мянга, уул уурхай, олборлолтын салбарт 8.0 хувь буюу 14.0 мянган ажиллагчид харьяалагдаж байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад өндөр үзүүлэлт байна.


Манай улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 91.7 хувь нь 1-19 хүртэлх тооны ажилтантай жижиг аж ахуйн нэгж байгууллага байдаг. ААНБ-ын дундаж ажилтны тоо 102.5 гарч байгаа ба энэ нь олон ажилтантай томоохон нэгжийг зорилтот бүлэг болгон түүвэрлэсэнтэй холбоотой.

Зураг 8. ААНБ, өмчийн хэлбэр, байршил /хэмжих нэгж: тоо/



Судалгаанд хамрагдсан ААНБ-ыг өмчийн хэлбэрээр авч үзвэл нийт хамрагдсан аж ахуйн нэгжийн 20.2 хувь буюу 0.4 мянга нь төрийн өмчийнх, 71.1 хувь буюу 1.5 мянга нь хувийн өмчийнх, 4.5 хувь буюу 0.09 мянга нь хувийн хамтарсан, 4.2 хувь нь буюу 0.08 мянга нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байжээ.

Улаанбаатар хотын ААНБ-уудын 77.5 хувь нь хувийн өмчийн, 13.2 хувь нь төрийн өмчийн байгууллага байгаа бол орон нутгийн ААНБ-уудын хувьд 60 хувь нь хувийн өмчийн байгууллага, 32 хувь нь төрийн өмчийн байгууллага тус тус эзэлж байна.

Зураг 9. ААНБ, үйл ажиллагааны хэлбэр /хэмжих нэгж: хувь/

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 76.3 хувь нь байнгын үйл ажиллагаа явуулдаг бол 17.3 хувь нь улирлын чанартай, 6.4 хувь нь тогтмол биш² үйл ажиллагааны дэглэмтэй ААНБ-үүд байна.

Бүс нутгийн байршлын хувьд хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 84.0 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 68.5 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бол барилгын салбарын 80.5 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 62.4 хувь, мэдээлэл холбооны салбарын 81.0 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны 82.0 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 74.6 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын 79.0 хувь нь тус тус Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.


Зураг 10. Ажилтны ажлын байрны хэлбэр, хүйсээр /хэмжих нэгж: тоо/

Судалгаанд хамрагдсан 2050 ААНБ-д 174.9 мянян ажилтан ажиллаж байгаагийн 93.4 хувь нь байнгын ажлын байранд, үлдсэн 6.6 хувь нь түр ажлын байранд ажиллаж байна. Мөн нийт ажиллагчдын 53 хувь нь, байнгын ажиллагчдын 52 хувь нь эрэгтэй ажилтан байгаа бол түр ажиллагчдын хувьд энэ үзүүлэлт өндөр буюу нийт түр ажиллагчдын 69 хувь нь эрэгтэй ажилтан байна.

² Ажлын захиалга орж ирсэн тухайн үед үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж


ААНБ-ын ажилтны тооноос харахад 150 болон түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгжийн 72.4 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бол 22.0 хувь нь хангайн болон төвийн бүсэд, 3.9 хувь нь зүүн бүсэд, харин 1.6 хувь нь баруун бүсэд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 11. Байнгын ажилтны боловсролын түвшин, хүйс /хэмжих нэгж: тоо/



ААНБ-ын байнгын ажилтны дунд бакалаврын болон бүрэн дунд боловсролтой ажилтан хамгийн их байгаа ба нийт байнгын ажилтны 64.9 хувь буюу 105.9 мянга байна. Харин бага боловсролтой болон боловсролгүй ажилтны тоо хамгийн бага буюу 1.3 мянга байгаа нь нийт байнгын ажилтны 0.8 хувийг эзэлж байна.

Зураг 12. Түр ажилтны боловсролын түвшин, хүйс /хэмжих нэгж: тоо, мянга/



Түр ажилтнуудын 42.5 хувь нь буюу 4.9 мянга нь бүрэн дунд боловсролтой ажиллагчид байгаа бол 24.7 хувь буюу 2.9 мянга нь магистр болон бакалавр зэрэгтэй ажиллагчид, 15.8 хувь нь буюу 1.8 мянга нь техник мэргэжлийн болон мэргэжлийн анхан шатны боловсролтой ажиллагчид байна. Түр ажилтнуудын хувьд 75.3 хувь

нь бакалавраас доош түвшний буюу тусгай мэргэжлийн болон бүрэн дунд, бага, боловсролтой ажиллагчид байна.

3.2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ

Барометрийн судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны төлөв байдлын эрэлтийн талаарх мэдээлэл өгдөгөөрөө онцлогтой. Энэ удаагийн судалгаагаар ирэх нэг жилийн хугацааны /2016 оны/ ажиллах хүчний хэрэгцээний талаарх мэдээллийг өгч байна.


Ирэх нэг жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан ААНБ-ын 40.2 хувь нь шинээр ажилтан авахаар төлөвлөж 59.8 хувь нь шинээр ажилтан авах төлөвлөгөөгүй байгаагаа илрэхийлжээ. Бус нутгаар нь авч үзвэл орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 47.8 хувь нь, Улаанбаатарын ААНБ-ын 35.9 хувь нь шинээр ажилтан авна гэсэн байна.

Үндсэн үр дүн


Судалгааны үндсэн үр дүнг түүврийн эх олонлогийн мэдээлэлд буюу 2014 оны жилийн эцсийн бизнес регистрийн сангийн мэдээлэлд тархааж авч үзлээ. Түүврийн аргачлалын дагуу эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал болон ажилтны тооны бүлгийг харгалзан үзэж үр дүнгийн тархаалтыг хийж гүйцэтгэсэн болно.

Судалгааны үр дүнг тархаалтын дүнгээр авч үзвэл хөдөлмөрийн зах зээлд ирэх нэг жилийн хугацаанд 80.1 мянган байнтын болон түр ажлын байр бий болох төлөвлтэй байна. Үүний 79.1 хувь буюу 63.4 мянган ажлын байр ирэх нэг жилийн эхний хагас жилд, үлдсэн 20.9 хувь буюу 16.7 мянга нь сүүлийн хагас жилд тус тус бий болохоор байна.

Зураг 13. Ирэх нэг жилийн хугацаанд шинээр ажилтан авах ААНБ, бус нутгаар
/хэмжих нэгж: хувь/



Бус нутгаар авч үзвэл баруун бүсийн аймгуудад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын 54.9 хувь, зүүн бүсийн ААНБ-уудын 46.3 хувь, төвийн бүсийн ААНБ-уудын 45.2 хувь нь тус тус шинээр ажилтан авах төлөвлөгөөтэй байгаа бол Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын хувьд 35.9 хувь нь шинээр ажилтан авна хэмээн хариулжээ.

Зураг 14. Ирэх нэг жилийн хугацаанд ажиллах хүчиний эрэлт /хэмжих нэгж: мян.хүн/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар ирэх нэг жилийн хугацаанд ажиллах хүчиний эрэлт бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн зэрэг салбаруудад өндөр байна. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдааны салбарт 24.6 мянган ажилтан, барилгын салбарт 11.5 мянган ажилтан, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.2 мянган ажилтан, хөдөө аж ахуйн салбарт 7.5 мянган ажилтан ажилд авахаар хүлээгдэж байна.

Ирэх нэг жилийн хугацааны эхний 6 сарын ажиллах хүчиний эрэлт


/2016.01-2016.07/

Ирэх нэг жилийн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд 80.1 мянган ажиллах хүчиний хэрэгцээ гарч байгаа бөгөөд үүний 79.1 хувь буюу 63.4 мянга нь эхний 6 сард бий болохоор байна. Энэ нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын ажилтны тоо 12.0 хувиар өсөх боломжийг бий болгох юм.

³ Түүврийн эх олонлогийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын тоо

Зураг 15. Эхийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар

/хэмжих нэгж: мян.хүн/



Эхний 6 сард бий болох нийт эрэлтийн 27.6 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, 15.5 хувь нь барилгын салбар, 11.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус бий болохор байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад хамгийн өндөр хувьтай байна.

Ирэх нэг жилийн хугацааны эхний 6 сард бий болох ажиллах хүчний эрэлтийг, бус нутгийн байдлаар тайлбарлавал Улаанбаатар хотод хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний эрэлт 11.5 хувиар өсөхөөр тооцоологдсон байна. Орон нутгийн хувьд хангайн бүсийн хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт илүү буюу 15.2 хувийн өсөлтийг харуулж байгаа нь таатай дүр зургийг харуулж байна. Харин төвийн болон зүүн бүсэд хамгийн бага буюу 10.4 хувийн өсөлт бий болохор байна.

Хангайн бүс болон төвийн бүс, баруун бүсүүдэд хөдөө аж ахуйн салбарын эрэлт онцгой анхаарал татах байгаа ба энэ нь бус нутгийн эрэлт хөдөө аж ахуйн салбарын эхний хагас жилийн нийт эрэлтийн 70.5 хувийг эзэлж байна. Мөн Улаанбаатар хот болон баруун бүс барилгын салбарын нийт эрэлтийн 90.3 хувь, хангайн бүсийн аймгууд бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт эрэлтийн 88.0 хувийг тус тус эзэлж байгаа нь тухайн бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хамгийн хүчтэй нөлөө үзүүлэх салбарууд болж байна.


Ирэх нэг жилийн хугацааны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт

/2016.07-2016.12/

Ирэх нэг жилийн хугацааны эхний 6 сард бий болох эрэлттэй харьцуулахад сүүлийн 6 сард хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлт буурах дүр зураг харагдаж байна. Энэ хугацаанд улсын хэмжээнд 16.7 мянган/нийт эрэлтийн 20.9 хувь/ ажиллах хүчний эрэлт бий болох ба энэ нь ажил эрхэлж буй иргэдийн тоог 3.2 хувиар өсгөх боломжтой байна.

Зураг 16. Сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар

/хэмжих нэгж:тоо,мянга/



Бөөний болон жижиглэнгийн худалдаа, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбар зэрэг цөөн тооны салбаруудыг эс тооцвол бусад салбаруудад ажиллах хүчний эрэлт маш бага үүсэхээр байна. Хамгийн өсөлттэй байгаа салбар бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар байгаа бөгөөд 42.0 хувь буюу 7.0 мянган ажиллах хүчний эрэлтийг ирэх нэг жилийн хугацааны сүүлийн 6 сард бий болгох нь судалгаанаас харагдаж байна. Энэ өсөлт улсын хэмжээнд жигд тархаалтyg үзүүлж чадахгүй байгаа ба Улаанбаатар хот болон хангайн бус энэ өсөлтийг бүхэлд нь тодорхойлж байна. Ирэх нэг жилийн хугацааны сүүлийн 6 сард бий болох нийт эрэлтэд хөдөө аж ахуйн салбарын эрэлт 12.1 хувь, боловсруулах үйлдвэрлэл 10.4 хувь, барилгын салбарын эрэлт 9.6 хувийг тус тус эзэлж байна.

Бүс нутгийн байршилаар Улаанбаатар болон төвийн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад ирэх нэг жилийн хугацааны сүүлийн 6 сард илүү олон тооны ажлын байр бий болох төлөвтэй байна.

Ирэх нэг жилийн хугацааны /2016 оны/ ажиллах хүчиний эрэлт


Улсын хэмжээнд ирэх нэг жилийн хугацаанд нийт 80.1 мянга гаруй сүл болон шинэ ажлын байр бий болж, хөдөлмөрийн зах зээл өмнөх жилүүдтэй нэгэн адил эзэрг өөрчлөлтийг хадгалсаар байна. Энэ хугацаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын ажилтны тоо 15.1 хувиар өсөх боломж байгааг харуулж байгаа юм.

Ажиллах хүчиний эрэлт хамгийн их байх салбарууд нь хөдөө аж ахуй, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд, бус нутгаар харвал Улаанбаатар хот болон хангайн бүс, төвийн бүсүүд байна. Дээрх салбаруудад ирэх жилийн нийт эрэлтийн 65.6 хувь нь бий болохоор тооцоологджээ.

Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар ирэх нэг жилийн хугацаанд ажиллах хүчиний эрэлтийн 30.6 хувь буюу 24.5 мянга, барилгын салбарт 14.3 хувь буюу 11.4 мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 11.4 хувь буюу 9.1 мянга, 9.3 хувь буюу 7.5 мянга нь хөдөө аж ахуйн салбарт тус тус бий болохоор байгаа нь хөдөлмөрийн зах зээлд эзэрг үр дүн үзүүлэх ажиллах хүчиний шингээлтийг бий болгох салбаруудад байна.

Зураг 17. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчиний эрэлт


/хэмжих нэгж: тоо, мянга/



Ирэх жилийн эхний 6 сарын ажиллах хүчиний эрэлт сүүлийн 6 сарын ажиллах хүчиний эрэлтээс 26.3 хувиар их байгаа нь хөдөлмөрийн зах зээлд улирлын нөлөө хадгалагдаж байгааг илтгэж байна.

Зураг 18. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлтийг бус нутгаар

/хэмжих нэгж: хувь/



Нийт эрэлтийн 57.2 хувь буюу 45.8 мянга нь Улаанбаатар хотод, 14.7 хувь буюу 11.8 мянга нь хангайн бүсэд, 13.1 хувь буюу 10.5 мянга нь төвийн бүсэд бий болохоор байна. Эрэлт өндөр байх бүсүүдийн ажиллах хүчиний өсөлтөд бөөний болон жижиглэн худалдааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт их нөлөө үзүүлж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбар ирэх нэг жилийн хугацаанд тухайн салбарын ажиллах хүчиний хэмжээг 33.0 хувиар нэмэгдүүлэх төлөв байдал ажиглагдаж байгаа нь энэ салбарын ажиллах хүчиний багтаамжийн хүчин чадлыг илтгэж байна. Улаанбаатар хотод 16.7 мянга, хангайн бүсэд 3.7 мянга, төвийн бүсэд 3.0 мянган ажлын байр тус тус бий болохоор байгаа нь эдгээр бүсүүд нь ирэх нэг жилийн хугацаанд энэ салбарын ажиллах хүчиний эрэлтэд илүү нөлөө үзүүлэх бус нутгууд байхыг харуулж байна.

Хэдийгээр хангайн бүс болон төвийн бүс нь орон нутгийн бусад бүсүүдтэй харьцуулахад илүү таатай хөдөлмөрийн зах зээлийн орчинг бий болгож байгаа боловч уул уурхайн салбар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбаруудын ажиллах хүчиний эрэлт энэ бүсийн ажиллах хүчиний өсөлтөд бага нөлөөлөхөөр байна.

Хөдөө аж ахуйн салбарыг онцгойлон авч үзэх шаардлага байгааг манай судалгааны үр дүн харуулсан. Энэ салбарын эрэлт нийт эрэлтийн 9.3 хувь буюу 7.5 мянга орчим ажлын байр бий болохоор байгаа боловч хангай болон төвийн бүсэд хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчиний эрэлт 55.2 хувь буюу 4.1 мянга байгаа нь ёмнөх оны судалгаатай адил үр дүнг харуулж байна.

Ирэх нэг жилийн хугацаанд ажиллах хүчиний эрэлт их байх салбарын нэг нь барилга ба энэ салбарын өсөлтөд Улаанбаатар хот болон баруун бүсийн аймгуудад бий болох олон тооны ажлын байр шууд нөлөө үзүүлжээ. Барилгын салбарын нийт эрэлтийн 8.4 мянга нь Улаанбаатарт, 1.9 мянга гаруй нь баруун бүсэд тус тус бий болохоор байна.

Бус нутгийн байдлаар Улаанбаатарт хамгийн олон тооны ажлын байр буюу нийт ажлын байрны 57.2 хувьтай тэнцэх 45.8 мянга нь бий болох юм. Түүний 78.5 хувь буюу 36.0 мянга нь байнгын ажлын байр, 21.5 хувь буюу 9.8 мянга нь түр ажлын байр байна. Энэ бүсийн нийт ажиллах хүчиний эрэлтэд бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд нөлөөлж байна.


Орон нутгаас хангайн бүс, төвийн бүсийн аймгуудад ажиллах хүчиний эрэлт бусад бүсийн аймгуудаас илүү их байх ба эдгээр бүсүүдэд 22.3 мянган ажлын

байр бий болох болон нөхөгдөхөөр тооцоо гарчээ. Ялангуяа хөдөө аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, бөөний болон жижиглэн худалдааны салбаруудад хөдөлмөр эрхлэх боломж илүү байхаар байна.

Харин зүүн бүсийн аймгуудад ажиллах хүчиний эрэлт бусад бүсүүдтэй харьцуулахад бага байх төлөвтэй байгаа хэдий ч цөөн тооны буюу 2.8 мянга гаруй ажлын байр бий болохоор байна.


Улаанбаатарт ажиллах хүчиний эрэлт орон нутгаас илүү байх ба байнгын ажилтны эрэлт Улаанбаатарт 78.5 хувь, орон нутагт 78.3 хувь, түр ажилтан Улаанбаатарт 21.5 хувь, орон нутагт 21.7 хувь байна.

Зураг 19. Ажиллах хүчиний эрэлт, өмчийн хэлбэрээр/хэмжих нэгж: тоо/



Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 40.2 хувьд ажиллах хүчиний эрэлт бий болохоор байгаа бөгөөд үүний 85.6 хувь нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байгаа бол, 3.6 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүд, 5.4 хувь нь төрийн өмчийн, аж ахуйн нэгж, байгууллагууд байгаа юм. Өөрөөр хэлбэл 2016 онд бий болохоор хүлээгдэж буй нийт эрэлтийн 85.6 хувь нь хувийн өмчийн ААНБ-д бий болохоор байгаа нь хувийн хэвшлийн ажил олгогч байгууллагууд хөдөлмөрийн зах зээлд тодорхой байр суурь эзэлж буйг харуулж байна.

Байнгын ажлын байрны нийт эрэлтийн 83.5 хувь нь буюу 52.5 мянга нь хувийн өмчийн ААНБ-дад бий болох бол 4.6 хувь нь буюу 2.9 мянга нь гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-д бий болох тооцоо гарсан байна. Харин түр ажлын байрны 93.3 хувь нь хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагад бий болохоор байна.

Зураг 20. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр/хэмжих нэгж:тоо/

Хөдөлмөрийн зах зээлд бий болох ажлын байрны нийлүүлэлтийг шинэ болон сул ажлын байрны төрлөөр ангилан үзсэнээр ажил эрхлэлтийн цэвэр өсөлтийн хэмжээг тооцох ач холбогдолтой юм. Барометрийн судалгаагаар тооцоологдсон нийт ажиллах хүчний эрэлтийн 60.4 хувь буюу 48.4 мянга нь шинэ ажлын байрны эрэлт байгаа нь ажил эрхлэлтийн хэмжээг мөн хэмжээгээр тэлж буйг харуулж байна.

Шинэ болон сул ажлын байрны эрэлтийн 90 гаруй хувь хувийн хэвшлийн байгууллагуудад бий болохоор байна.

Эрэлтийн 39.6 хувь буюу 31.7 мянга нь сул ажлын байрны эрэлт байна.

Зураг 21. Сул ажлын байр бий болсон шалтгаан /хэмжих нэгж: хувь /

Сул ажлын байрны эрэлт бий болох шалтгааныг тодруулахад 10.1 хувь нь халагдсан, 30.8 хувь нь өөрийн хүсэлтээр ажлаас гарсан байгаа бөгөөд 39.1 хувь нь бусад шалтгаан буюу хувь хүний төлөвшил, харилцаа, хандлагаас үүдсэн шалтгаанаар ажлын байраа орхисон байна. Үүнийг ажиллах хүчний тогтвортгуй байдалтай холбон тайлбарлаж болох юм.

Хүснэгт 10. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбар, хугацаагаар /хэмжих нэгж: тоо/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Байнгын ажиллах хүчний эрэлт			Түр ажиллах хүчний эрэлт		
	Эхний 6 сар	Дараагийн 6 сар	Нийт	Эхний 6 сар	Дараагийн 6 сар	Нийт
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4420	1037	5457	1023	995	2018
Уул уурхай, олборлолт	1369	17	1386	64	255	319
Боловсруулах үйлдвэрлэл	6309	664	6973	1079	1083	2161
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1477	158	1635	33	42	75
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	136	29	165	4	4	8
Барилга	5987	616	6602	3857	983	4840
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	13842	5848	19690	3664	1189	4853
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1838	86	1924	334	5	339
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1790	554	2345	222	83	305
Мэдээлэл, холбоо	792	225	1017	212	0	212
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1293	25	1318	189	0	189
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	363	30	394	8	0	8
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1853	236	2090	430	224	654
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1474	364	1838	292	246	538
Боловсрол	1493	928	2421	288	85	373
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1541	56	1598	163	23	186
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1448	272	1719	149	48	197
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3949	329	4279	11	0	11
Нийт	51374	11476	62850	12020	5264	17284

Ирэх нэг жилийн хугацаанд бий болох ажлын байрны 78.0 хувь буюу 62.9 мянга нь байнгын ажлын байр, 22.0 хувь буюу 17.3 мянга нь түр ажлын байр байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилаар авч үзэхэд байнгын ажлын байрны хувьд шинээр ажилтан авах хэрэгцээ бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбаруудад өндөр хувийг эзэлж байна.

Байнгын ажлын байрны 81.7 хувь нь эхний 6 сард бий болохоор байгаа бол түр ажлын байрны 69.5 хувь нь эхний 6 сарын хугацаанд бий болохоор байна.

Хүснэгт 11. Ойрын нэг жилийн хугацааны ажиллах хүчиний эрэлт /хэмжих нэгж: тоо, хувь/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчиний эрэлт	Эхний 6 сар		Дараагийн 6 сар	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агуулур	7475	5443	72.8	2032	27.2
Уул уурхай, олборлолт	1705	1433	84.0	272	16.0
Боловсруулах үйлдвэрлэл	9134	7388	80.9	1746	19.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1710	1510	88.3	201	11.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	173	140	81.0	33	19.0
Барилга	11442	9843	86.0	1599	14.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	24543	17507	71.3	7036	28.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2263	2172	96.0	91	4.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2649	2012	76.0	637	24.0
Мэдээлэл, холбоо	1229	1004	81.7	225	18.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1506	1482	98.4	25	1.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	401	371	92.4	30	7.6
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2744	2283	83.2	461	16.8
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2376	1766	74.3	610	25.7
Боловсрол	2794	1781	63.7	1013	36.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1784	1705	95.6	79	4.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1916	1597	83.3	320	16.7
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4289	3960	92.3	329	7.7
Нийт	80134	63394	79.1	16740	20.9

Ирэх нэг жилийн хугацаанд бий болох эрэлтийн 79.1 хувь нь 2016 оны эхний хагас жил хамарч байгаа бөгөөд энэ хугацааны ажиллах хүчний өндөр эрэлтийг улирлын чанартай, түр ажлын байранд олон тооны ажиллах хүчний эрэлт бий болдогтой холбон тайлбарлаж болох юм.

Энэ хугацаанд бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбаруудад ажиллах хүчний эрэлт түлхүү харагдаж байна.

Хүснэгт 12. Ажиллах хүчний эрэлт, салбараар, шинэ болон сүл ажлын байрны төрлөөр /хэмжих нэгж: тоо, хувь/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Шинэ ажлын байр		Сүл ажлын байр	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4947	66.2	2528	33.8
Уул уурхай, олборлолт	1232	72.3	473	27.7
Боловсруулах үйлдвэрлэл	5466	59.8	3668	40.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1017	59.5	693	40.5
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	116	67.0	57	33.0
Барилга	6595	57.6	4847	42.4
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	14061	57.3	10482	42.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1386	61.3	877	38.7
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1476	55.7	1174	44.3
Мэдээлэл, холбоо	838	68.2	390	31.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1112	73.8	394	26.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	139	34.6	263	65.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1730	63.0	1014	37.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1129	47.5	1247	52.5
Боловсрол	1706	61.1	1088	38.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1015	56.9	769	43.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2949	153.9	1340	69.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1474	34.4	442	10.3
Нийт	48389	60.4	31746	39.6

Ирэх нэг жилийн хугацаанд ажлын байр 16.5 хувиар өсөх хандлагатай байгаа ба үүнээс 9.9 хувийн өсөлт нь шинэ ажлын байрны хувьд, 6.5 хувь нь сүл ажлын байрыг нөхөх зорилготой байна. Энэ нь манай эдийн засгийн зарим салбар эрчимтэй хөгжиж шинээр олон тооны ажлын байр бий болж байна гэдгийг илтгэж байна. Шинээр бий болж буй ажлын байрны 29.1 хувь нь бөөний болон жижиглэнгийн

худалдааны салбарт, 13.6 хувь нь барилгын салбарт, 11.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бий болохоор харагдаж байна. Сул ажлын байрны ажиллах хүчний эрэлт бусад салбаруудтай харьцуулахад барилга, бөөний болон жижиглэн худалдааны салбаруудад өндөр байна.

Барометрийн судалгааны үндсэн үр дүнгийн нэг нь ажил мэргэжлийн эрэлтийн тооцоолол байдаг. Энэхүү мэдээлэл хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангахад чухал хувь нэмэр оруулдаг.

Ирэх нэг жилийн хугацаанд эрэлт ихтэй байхаар тооцологдсон 20 ажил мэргэжлээрх эрэлт нь нийт ажиллах хүчний эрэлтийн 52.2 хувийг эээлж байгаа ба эдгээр эрэлттэй ажил мэргэжлүүд нь төрөл бүрийн салбарт тархсан ч жолооч, барилгын туслах ажилтан, тогооч, хамгаалагч зэрэг ажил мэргэжлүүд буюу тусгайлсан мэргэжил шаардахгүй ажлын байр давамгайлж байна.

Хүснэгт 13. Хэрэгцээтэй ажиллах хүч /YAMAT-08/


Мэргэжлийн нэр	Мэргэжлийн код	Ажиллах хүчний эрэлт / хувь /
Жолооч	8322	12.4
Хамгаалагч	5414	9.8
Барилгын туслах ажилтан	9312	9.0
Тогооч	5120	7.1
Үйлдвэрийн туслах ажилтан	9329	5.7
Эмч	2211	5.3
Сувилагч	2221	5.1
Нягтлан бодогч	2411	4.8
Бизнесийн удирдлага	1211	4.8
Санхүүгийн шинжээч	2431	4.6
Ачигч	9333	4.4
Багш	2310	4.0
Үйлчлэгч	9112	3.8
Инженер	2141	3.6
Операторч	8342	3.5
Барилгачин	7111	2.7
Мужаан	7522	2.6
Барилгын инженер	2142	2.5
Зөөгч бармен	5131	2.3
Сантехникч	7126	2.2

Тайлбар: Ажиллах хүчний эрэлтийн ажил мэргэжлээрх мэдээлэл нь эх олонлогт тархаагаагүй ба судалгааны үр дунгээр тодорхойлогдсон тоо хэмжээ юм.

3.3 Ажиллах хүчний дутагдал, бэрхшээл

Барометрийн судалгааны зорилтын нэг нь өнгөрсөн нэг жилийн хугацааны хөдөлмөрийн зах зээлдэх ажиллах хүчний дутагдлыг илрүүлэх явдал юм. Судалгаагаар ажиллах хүчний дутагдлын дарамтыг тодорхойлохын хажуугаар шинэ ажилтан авахад тулгардаг хүндэрэл бэрхшээл, шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалжийн талаарх мэдээллийг судалдаг. Энэ удаагийн түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн 13.6 хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд зохих мэргэжилтэй ажилтан олдохгүй байснаас шалтгаалж шинээр ажилтан авч чадаагүй буюу ажиллах хүчний дутагдалд орсон байна.

Зураг 22. Зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бус нутгаар /хэмжих нэгж: хувь/



Ажиллах хүчний дутагдалд орсон ААНБ-ыг бүсээр тархаан авч үзвэл орон нутгийн хэмжээнд өнгөрсөн жилийн хугацаанд нийт ААНБ-ын 18.3 хувь нь ажиллах хүчний дутагдалд орсон бэрхшээл байсан ба баруун болон зүүн бүсэд энэ бэрхшээл илүү байж, зүүн бүсийн ажил олгогчдын 25.1 хувь, баруун бүсийн ажил олгогчдын 21.3 хувийг тус тус хамарсан байна. Улаанбаатар хотын ААНБ-үүд ажиллах хүчний дутагдалд орсон байдал бусад бүсүүдтэй харьцуулахад бага буюу нийт ААНБ-ын 10.9 хувийг эзэлжээ.


Зураг 23. Ажиллах хүчний дутагдалд орсон ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар /хэмжих нэгж: хувь/



Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар ажиллах хүчний дутагдал өндөр байсан бөөний болон жижиглэн худалдаа /27.3 хувь/, боловсруулах үйлдвэрлэл /18.4 хувь/, үйлчилгээний бусад үйл ажиллагаа /8.9 хувь/ зэрэг салбарууд байжээ.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын мэдээллийг эх олонлогт тархаан үзвэл өнгөрсөн нэг жилийн хугацааны ажиллах хүчний дутагдлын тоо хэмжээ 16.7 мянга орчим ажилтан болж байна.

Зураг 24. Ажиллах хүчний дутагдал, байгууллагын өмчийн хэлбэр, хүйсээр /хэмжих нэгж: тоо/



Төрийн өмчийн хэлбэрийн ААНБ-үүд 0.8 мянга, хувийн өмчийн хэлбэрийн ААНБ-үүд 17.5 мянга, хувийн хамтарсан өмчийн хэлбэрийн ААНБ-үүд 1.0 мянга, гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-үүд 0.1 мянган ажилтныг өнгөрсөн 12 сарын хугацаанд авч ажиллуулах боломжкоо алдан, ажиллах хүчний дутагдалд оржээ.

Хүснэгт 14. Ажиллах хүчиний дутагдал, бүсээр, ажилтны тоо, хүйсээр, ААНБ-ын тоогоор /хэмжих нэгж: тоо, хувь/

Аймаг, хот	ААНБ-ын тоо			Ажилтны тоо		
	Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо	Ажилтан авч чадаагүй	Хувь	Эмэгтэй	Хүйс харгалзахгүй	Дүн
Улаанбаатар	1306	192	14.7	1035	6634	7668
Зүүн бүс	95	16	16.8	82	1276	1358
Төвийн бүс	259	51	19.7	48	1940	1989
Хангайн бүс	226	47	20.8	336	2986	3322
Баруун бүс	164	26	15.9	398	1962	2360
Орон нутгийн бүс	744	140	18.8	864	8164	9028
Дүн	2050	332	16.2%	1899	14798	16697

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагуудад дутагдалтай байсан 16.7 мянга гаруй ажилтны 11.4хувь буюу 1.9 мянга нь эмэгтэй, 88.6 хувь буюу 14.8 мянга нь хүйс харгалзахгүй ажилтан авахаар байсан байна. Бүсийн тархалтаар хүйсийн хувьд ажиллах хүчиний дутагдал харилцан адилгүй байна. Орон нутагт хүйсийн харьцаа харилцан адилгүй байгаа ба төвийн бүсэд эрэгтэй ажиллах хүчиний эрэлт ихтэй байжээ. Улаанбаатар хотын хөдөлмөрийн зах зээлд дутагдалтай байсан нийт ажиллах хүчиний дийлэнх нь буюу 86.5 хувь нь эрэгтэй ажиллах хүчиний эрэлт байсан байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан хий агааржуулалтын хангамжийн салбарууд хамгийн олон тоогоор ажлын байрны нөөцөө бүрэн ашиглаж чадаагүй байна. Үүнийг эдгээр салбаруудад эрэлт их байгаа ч нийлүүлэлт хангалттай хэмжээнд хийгдэхгүй байгаатай холбон тайлбарлаж болох юм. Харин санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхай олборлолт, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчиний дутагдал хамгийн бага байжээ. Энэ нь эдгээр салбаруудад ажиллах хүчиний эрэлт бага байсан, негөө талаас эдгээр салбарын мэргэжлүүд нь салбар хооронд шилжих боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой юм.

Хүснэгт 15. Ажиллах хүчиний дутагдал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажилтны хүйсээр /хэмжих нэгж: тоо, хувь/

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Дутагдалтай байсан ажилтны тоо					
	Эмэгтэй		Хүйс харгалзахгүй		Дүн	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	33	1.7	1091	7.3	1507	7.7
Уул уурхай, олборлолт	54	2.8	140	0.9	160	0.8

Боловсруулах үйлдвэрлэл	338	17.8	1800	12.1	2201	11.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	17	0.9	1960	13.2	2045	10.5
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0	0.0	28	0.2	28	0.1
Барилга	24	1.3	1753	11.8	2776	14.3
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	572	30.1	2579	17.3	3613	18.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0	0.0	657	4.4	744	3.8
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	157	8.3	540	3.6	775	4.0
Мэдээлэл, холбоо	0	0.0	282	1.9	288	1.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	0.0	96	0.6	96	0.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	31	1.6	171	1.2	202	1.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	14	0.7	1262	8.5	1304	6.7
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	8	0.4	301	2.0	411	2.1
Боловсрол	71	3.7	569	3.8	666	3.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	239	12.6	294	2.0	635	3.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	17	0.9	343	2.3	356	1.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	326	17.2	1008	6.8	1648	8.5

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ салбарт зохих мэргэжилтэй ажиллах хүч олдоогүйн улмаас 3.6 мянган сүл орон тоо байсан нь 18.6 хувийг эзэлж байна. Барилгын салбарт 2.8 мянган ажлын байр, боловсруулах үйлдвэрлэлийн 2.2 мянган ажлын байр байсан ч зохих мэргэжилтэй ажилтан авч чадалгүй ажиллах хүчний дутагдалтай ажилласан судалгааны үр дүн гарчээ.

Хүснэгт 16. Ажиллах хүчний дутагдал, ажил мэргэжлээр

/хэмжих нэгж: хувь/

Мэргэжлийн нэр	YAMAT-05	Дутагдал /Хувь/
Зөөгч	5131	10.1
Эмч	2212	8.7
Тогооч	5120	7.6
Цахилгаанчин	7411	7.3
Засал чимэглэл	7123	7.2
Сантехникч	7126	7.1
Мужаан	7522	6.8
Гагнуурчин	7212	6.4
Жолооч	8322	5.0
Үйлдвэрийн туслах ажилтан	9329	4.8
Сувилагч	2221	4.5
Механик инженер	2144	3.7
Гадаад хэлний багш	2353	3.5
Барилгын туслах ажилтан	9312	3.1
Өндрийн буулт хийгч	3421	2.7
Арматурчин	7114	2.4
Инженер	2141	2.4
Нярайн сувилагч	2221	2.3
Хүнсний ногоо тариалагч	6111	2.2
Программ хангамжийн инженер	2512	2.2

Тайлбар: Ажиллах хүчний дутагдлын ажил мэргэжлээрх мэдээлэл нь эх олонлогт тархаагаагүй ба судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон тоо хэмжээ гэж ойлгоно.

Ажиллах хүчний дутагдлыг ажил мэргэжлээр судлан үзвэл зөөгч, эмч, тогооч, цахилгаанчин, мөн барилгын өргөн мэргэжлийн чиглэлийн мэргэжлүүд давамгайлжээ.

3.4. Шинэ ажилтан авахад ашигласан мэдээллийн эх сурвалж

Судалгаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагын шинээр ажилтан авахад хэрэглэдэг мэдээллийн эх сурвалжийг судлан үзэхэд сонин, телевизийн зар, интернет, цахим мэдээллээр ажилтнаа сонгон шалгаруулж хүний нөөцөө бүрдүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд хамгийн их буюу 33.6 хувийг эзэлж байна. Түүнчлэн ажил хайгч иргэд өөрөө ажил олгогчид хандан ажилтай болох нь хөдөлмөрийн зах зээлд элбэг байдаг ба энэ нь 12.3 хувийг эзэлж байна. Орон нутгийн ажил олгогчдын 10.1 хувь нь хөдөлмөрийн хэлтсүүдээр дамжуулан, 17.5 хувь нь сонин телевизийн зараар ажилтан авч чадсан гэж хариулжээ. Үүнээс үзэхэд Хөдөлмөрийн хэлтсүүдийн үйл ажиллагаа орон нутагт илүү хүртээмжтэй, хэрэгцээтэй байдаг байна.

Зураг 25. Шинэ ажилтан авахад ашиглсан мэдээллийн эх сурвалж /хэмжих нэгж: хувь/



ААНБ-уудын хамгийн багаар нэрлэсэн эх сурвалж нь зуучлалын байгууллагууд буюу хөдөлмөрийн хувийн биржүүд ба эдгээр байгууллагуудын ихэнх нь Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үйлчилгээ нь хэрэглэгчдэд танигдаж, хүртээмжтэй болж чадаагүйтэй холбоотой байж болох юм.

Иргэд сонин, телевизийн зар, интернетийн орчноос ажлын байр хайх нь түгээмэл ажиглагдаж байна. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажил олгогчид ажилд орох хүсэлтээ илэрхийлсэн иргэдийн 57.4 хувь, барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орох хүсэлтээ илэрхийлсэн иргэдийн 65.2 нь энэ эх сурвалжийг ашиглсан байна. Ихэнх салбарын ААНБ-ын хувьд сонин, телевизийн зараар ажилтан авдаг нь ажиглагдаж байна./Хавсралт 4/


3.5. Ажил олгогчийн бэрхшээл

Судалгаанд оролцогч ААНБ-аас хөдөлмөрийн харилцаанд оролцох явцад тохиолддог бэршээлийн талаар тодруулсан.

Ажил олгогчид хамгийн их тохиолддог бэрхшээлээ дараах байдлаар нэрлэжээ. Нийт ажил олгогчдын 83.8 хувь нь ажилтан авахад хүндэрэл бэрхшээл тулгарч байгаагүй гэсэн байна. Харин хүндэрэл бэрхшээл тохиолддог гэж хариулсан ажил олгогчдын хувьд 28.1 хувь нь тусгай зөвшөөрөл, эрхтэй байх, 21.1 хувь нь ажлын туршлага дутмаг, 14.2 хувь нь боловсрол, мэргэжлийн түвшин, ажлын байрны шаардлагад нийцэхгүй гэсэн бэрхшээлүүдийг дурьдсан байна. Мөн дээрх шалтгаанаас бусад буюу хувь хүний суурь хүмүүжил, төлөвшлөөс хамааралтай / ажилдаа хариуцлагагүй ханддаг, цалин голдог, тогтворт суурьшилгүй/ шалтгааныг 10.2 хувь нь нэрлэсэн байна.

Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь нарийн мэргэжлийн, чадварлаг боловсон хүчин байхаас гадна хувь хүний төлөвшил, тогтворт суурьшил, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна.

Зураг 26. Ажил олгогчийн бэрхшээл: шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл /хэмжих нэгж: хувь/



3.6. Өмнөх судалгааны үр дүнгийн харьцуулалт

Барометрийн судалгаа нь түүвэрт хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагуудаа дахин сонгож, тогтмол хугацааны давтамжтайгаар явуулж чадвал хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчиний хөдөлгөөний зүй тогтлыг тодорхойлох ач холбогдолтой арга хэрэгсэл болдог. Судалгааг тогтмол явуулснаар эхний судалгаагаар тодорхойлсон ажиллах хүчиний эрэлт хэрэгцээг баталгаажуулж өгдөг. Жил дараалан гүйцэтгэсэн барометрийн судалгааны үр дүнг харьцуулан, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн талын дунд хугацааны ерөнхий дүр зургийг харж болох юм.

Жил бүрийн судалгаануудын түүврийн хэмжээ өөр өөр байгаа ч арга зүй нь ижил, тодорхойлж буй үр дүнгийн мэдээллийн бүтэц, агуулга нь адил учраас харьцуулалт хийх боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 17. Судалгаанд хамрагдсан ААНБ, ажилтны тооны бүлгээр/хэмжих нэгж: тоо, хувь/

Судалгааны дүн		1-10 ажилтан	11-50 ажилтан	51-250 ажилтан	251 ба түүнээс дээш	Дүн
2012 он	тоо	995	1252	517	109	2873
	хувь	34.6%	43.6%	18.0%	3.8%	100%
2013 он	тоо	683	475	347	121	1644
	хувь	41.5%	28.9%	21.1%	7.4%	100%
2014 он	тоо	553	467	555	147	1722
	Хувь	32.1%	27.1%	32.2%	8.5%	100%
2015 он	тоо	825	613	478	134	2050
	хувь	40.2%	29.9%	23.3%	6.5%	100%

Үндэсний статистикийн хорооны бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 90 орчим хувь нь 20-оос доош ажилтантай ажил олгогчид бүрдүүлдэг. Тиймээс жил бүрийн судалгааны түүврийн хэмжээнд


энэ бүлгийн ажил олгогчдын эзлэх хувь өндөр байдаг. Энэ жилийн судалгааны түүврийн хувьд ч 1-10 хүртэлх ажилтантай ажил олгогчид 40.2 хувийг эзэлж байна. Мөн энэ жил өмнөх жилийн судалгааны нэгэн адил олон ажиллагчидтай буюу 150-ээс дээш ажиллагчидтай ажил олгогчийг нэлэнхүй байдлаар түүвэрт хамруулсан. Ажилтны тооны бүлгээр олон ажиллагчид /50 –дээш/-тай ажил олгогчдын бүлэг 2014 онд хамгийн их буюу нийт түүврийн 40.8 хувийг эзэлж байжээ.

2014 оны барометрийн судалгаанд 100, түүнээс дээш тооны ажилтантай 517 ААНБ-ыг ямар нэгэн түүвэрлэлт хийхгүйгээр хамруулсан учраас тухайн бүлгүүдийн түүврийн хамралтын жин өмнөх онуудтай харьцуулахад өндөр байна.

Улсын хэмжээнд ажиллах хүчиний эрэлт 2012 онд 22.5 хувь, 2013 онд өмнөх онтой харьцуулахад 7.6 хувиар буурч 14.9 хувь байсан бол 2014 онд өмнөх онтой харьцуулахад 4.2 хувиар өсөж 19.1 хувийн өсөлт бий болсон ба 2015 оны судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн зах зээл эерэг өөрчлөлтийг үзүүлж ажиллах хүчиний хэрэгцээ өсөх тооцоо гарсан. Үүнээс жил ирэх тусам хөдөлмөрийн зах зээлийн багтаамж тэлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломж байгааг харж болохоор байна.

Монгол улсын эрс тэс уур амьсгалтай холбоотойгоор эдийн засгийн зарим салбаруудад улирлын нөлөө ихтэй байдаг. Жил бүрийн судалгааны үр дүнгээр барилга, уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад хөдөлмөрийн эрэлт өндөр байгаа ба хөдөлмөрийн зах зээлд улирлын нөлөөлөл уламжлагдаж байгааг илэрхийлж байна.


Зураг 27. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчиний эрэлт, салбараар /хэмжих нэгж: хувь/



2015 оны судалгааны үр дүнг өмнөх онуудын судалгааны дүнтэй харьцуулахад бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээний салбар, хөдөө аж ахуйн салбаруудын ажиллах хүчний эрэлт өссөн дүнтэй харагдаж байна. Харин барилга болон уул уурхайн салбаруудын хувьд эрэлт буурсан байна.

Зураг 28. Ирэх нэг жилийн хугацааны ажиллах хүчний эрэлт, бус нутгаар

/хэмжих нэгж: хувь/



Бус нутгийн байршлын хувьд нөхцөл байдал нэлээд тогтвортгүй байна. Улсын хэмжээнд Улаанбаатар болон төвийн бусад ажиллах хүчний эрэлт их байдаг ч эдгээр бусийн хөдөлмөрийн зах зээлийн багтаамжийн тэлэх, хумих шинж чанар он хооронд хэлбэлзэлтэй байсаар байгаа юм.

Ажил мэргэжлийн эрэлтийн байдлыг харьцуулсан шинжилгээний үр дүнг тайлбарлавал хэд хэдэн нийтлэг төлөв байдал хадгалагдаж байгаа юм. Үүнд:

- Ажиллах хүчний эрэлт ихтэй эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын ажил мэргэжлүүд хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй ажил мэргэжлүүдийг тодорхойлж байна. Ялангуяа барилгын салбарын олон ажил мэргэжлүүд сүүлийн жилүүдэд дараалан хийсэн судалгаа бүрт эрэлттэй ажил мэргэжлүүдээр нэрлэгдсэн .
- Хөдөлмөрийн зах зээл дээд боловсролын нийлүүлэлтээс илүүтэйгээр мэргэжлийн боловсролын нийлүүлэлтийг шингээх боломж өндөр байсаар байна. Судалгаагаар тодорхойлогдож буй эрэлттэй ажил мэргэжлүүдийн дотор мэргэжлийн анхан шатны болон тусгай мэргэжлийн дунд боловсролоор эзэмшиүүлдэг үр чадварууд тулхүү байгаа юм.
- Зарим нэг энгийн ажил мэргэжлүүдээр олон тооны ажиллах хүч эрэлттэй байдаг. Тухайлбал барилга угсралтын болон үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтны хэрэгцээ жил бүр их байсаар байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг зөв бодлого, үйл ажиллагаагаар зохион байгуулж чадвал манай улсын хөдөлмөрийн нөөц дэх хамгийн өндөр жинтэй бүлэг болох бүрэн дунд боловсролтой ажиллах хүчинийг ажилтай болгоход чухал ач холбогдолтой гэж үзэж байна.
- Жил бүрийн судалгаанд авто машины жолооч, тогооч, оёдолчин зэрэг ажил мэргэжлүүд эрэлттэй ажил мэргэжлүүдээр тодорхойлогдсон байгаа нь эдгээр мэргэжлүүд төрөл бүрийн салбаруудад хэрэгцээтэй байдагтай холбоотой юм.
- Уул уурхайн салбар нь эрэлт ихтэй барилга, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй зэрэг салбаруудтай харьцуулахад ажиллах хүчиний хэрэгцээ бага байдаг ч гэсэн тодорхой ажил мэргэжлүүд нь зах зээлд эрэлттэйгээр тооцоологдож байсан. Гэвч жил ирэх тусам уул уурхайн салбарын ажил мэргэжлийн эрэлт багасаж байгааг судалгааны үр дүнгүүд харуулж байна.

Хүснэгт 18. Ажил мэргэжлийн эрэлт, /оноор/

2015 оны судалгааны үр дүн		2014 судалгааны үр дүн		2013 судалгааны үр дүн		2012 судалгааны үр дүн	
ҮАМАТ-08	Ажил мэргэжлийн нэр	ҮАМАТ-08	Ажил мэргэжлийн нэр	ҮАМАТ-08	Ажил мэргэжлийн нэр	ҮАМАТ-08	Ажил мэргэжлийн нэр
8322	Жолооч	9329.12	Үйлдвэрийн туслах ажилтан	9313.11	Туслах ажилтан /барилга угсралтын, барилгын талбай газар цэвэрлэх/	5242.12	Борлуулагч
5414	Хамгаалагч	9312.11	Барилгын туслах ажилтан	8332.13	Жолооч /ачааны тэрэгний, цемент зурагч, тээвэрлэгч машины/	9313.11	Туслах ажилтан, барилга угсралтын
9312	Барилгын туслах ажилтан	8332.12	Тоног төхөөрөмжийн оператор	5242.11	Үзүүлэн таниулж худалдаалагч	6111.00	Тариаланч, ногоочин
5120	Тогооч	7114.11	Арматурчин	9329.12	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	9329.12	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
9329	Үйлдвэрийн туслах ажилтан	2221.11	Сувилагч	7123.14	Шаварчин-засалчин, засал чимэглэлийн	5414.00	Хамгаалалтын албаны ажилтан
2211	Эмч	8322.11	Жолооч	5120.11	Тогооч	8322.11	Жолооч /такси, бүхээгт тэрэг, ачааны том тэрэг/
2221	Сувилагч	7115.11	Барилгын мужаан	7111.11	Барилгачин	5120.00	Тогооч
2411	Нягтлан бодогч	7123.14	Барилгын дотоод засал	5114.00	Харуул хамгаалалтын албаны ажилтан	5131.11	Зөөгч
1211	Бизнесийн удирдлага	9311.12	Уул уурхайн туслах ажилтан	2221.11	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	8332.00	Хүнд даацийн машин, том тэрэгний жолооч
2431	Санхүүгийн шинжээч	2145.24	Хүнсний технологийн ажилтан	5230.11	Дэлгүүрийн кассчин	7123.11	Засалчин, шаварчин
9333	Ачигч	2152.25	Сүлжигч	5412.12	Цагдаа	7115.11	Барилга угсралтын мужаан

2310	Багш	9333.15	Ачигч агуулахын	2151.11	Инженер, цахилгааны	7112.00	Өрлөгчин, холбогдох бусад ажилтан
9112	Үйлчлэгч	7533.11	Оёдолчин	5131.11	Зөөгч	7114.13	Зам индүүдлэгийн ажилтан
2141	Инженер	7112.13	Өрлөгчин, шаварчин	7114.11	Арматурчин	7114.11	Арматурчин
8342	Операторч	8111.15	Баяжуулахын оператор	7113.18	Зүсэгч, чулуу	7212.14	Гагнуурчин
7111	Барилгачин	7212.14	Гагнуурчин	7411.11	Цахилгаанчин	5223.11	Худалдаачин / жижиглэнгийн газрын/
7522	Мужаан	2411.13	Нягтлан бодогч	2411.12	Ахлах нягтлан бодогч	7411.11	Цахилгаанчин
2142	Барилгын инженер	5120.11	Тогооч	4311.20	Теллер банкны	1221.00	Борлуулалт, маркетингийн менежер
5131	Зөөгч бармен	9112.11	Цэвэрлэгч, албан тасалгааны	7115.11	Барилга угсралтын мужаан	2145.24	Технологич, хүнс, ундааны
7126	Сантехникч	7411.11	Цахилгаанчин	7112.12	Өрөгч, тоосгон гүүрний	2411.00	Нягтлан бодогч

ДҮГНЭЛТ

Ирэх нэг жилийн хугацаанд буюу 2016 онд Монгол улсын хэмжээнд 80.1 мянган ажилтны эрэлт үүсэх бөгөөд үүний 79.1 хувь нь оны эхний хагас жилд, үлдсэн 20.9 хувь нь оны сүүлийн хагас жилд бий болохоор байна. Түүнчлэн нийт хөдөлмөрийн эрэлтийн 78.4 хувь нь байнгын, 21.6 хувь нь түр ажлын байрны эрэлт болно.

Нөгөөтэйгүүр нийт хөдөлмөрийн эрэлтийн 60.4 хувь нь шинэ ажлын байр бол, 39.6 хувь нь сул ажлын байр байна.

Нийт хөдөлмөрийн эрэлтийн 30.6 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа(24.5мян),14.3 хувь (11.4 мян) барилга, 11.4 хувь (9.1мян)боловсруулах үйлдвэрлэл,9.3 хувь (7.5 мян) хөдөө аж ахуйн салбаруудад ногдож байна.

Хөдөлмөрийн эрэлт ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл жолооч, хамгаалагч, барилгын туслах ажилтан, тогооч, үйлдвэрлэлийн туслах ажилтан, эмч сувилагч зэрэг мэргэжлүүд хамгийн өндөр хувийн жин эзэлж байна.

Судалгаагаар өнгөрсөн 12 сарын хугацаанд аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 16.7 мянган ажиллах хүчиний дутагдалтай байсан гэсэн үр дүн гарсан бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан хий агааржуулалтын хангамжийн салбарууд хамгийн олон тоогоор ажлын байрны нөөцөө бүрэн ашиглаж чадаагүй байна. Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилга, цахилгаан хий агааржуулалтын хангамж гэсэн 4 салбарт нийт ажиллах хүчиний дутагдалын 54.7 хувь ногдож байна. Харин санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхай олборлолт, усан хангамж, бохир ус, хог, хаягдын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчиний дутагдал хамгийн бага байжээ.

Ажил олгогчид шинээр ажилтан авахад сонин, телевизийн зар, интернетийн мэдээллийг тулхүү ашигладаг нь ажиглагдаж байна.

Ажиллах хүчиний хомсдол бий болоход ажил олгогчдын хувьд ажилтан авах, эрэлхийлэх арга зам, мэдээллийн хүртээмжгүй байдал, ажлын байрны нөхцөл, боломжийг бүрэн хангаж чадаагүй байдал, ажил хайгчийн хувьд ажлын байрны талаарх мэдээллийн дутагдалтай байдал, мэдлэг, ур чадварын хомсдол, ажил олгогчийн сэтгэл ханамж зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

ХАВСРАЛТ



ХАВСРАЛТ 1. Ирэх нэг жилийн хугацааны эхний 6 сарын ажиллах хүчиний эрэлт

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Улаанбаатар		Зүүн бүс		Төвийн бүс		Хангайн бүс		Баруун бүс		Нийт дунгэр	
	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.8%	1058	22.3%	550	19.0%	1242	13.9%	1348	19.1%	1246	8.6%	5443
Уул урхай, опбориолт	2.2%	825	2.2%	55	0.1%	5	0.2%	21	8.0%	525	2.3%	1433
Боловсрullaх үйлдвэрлэл	10.7%	4080	10.1%	250	13.9%	911	10.5%	1021	17.2%	1125	11.7%	7388
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.2%	58	12.5%	308	0.4%	24	5.1%	498	9.5%	622	2.4%	1510
Усан хангамж; бөхирдус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.1%	44	0.0%	1	0.4%	24	0.7%	72	0.0%	0	0.2%	140
Барилга	20.1%	7691	11.8%	292	7.2%	470	2.0%	195	18.3%	1194	15.5%	9843
Бөвний болон жижигэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлилзээ	31.9%	12165	0.7%	16	19.8%	1296	33.8%	3273	11.6%	756	27.6%	17507
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.5%	1711	2.3%	57	0.8%	52	0.1%	10	5.2%	342	3.4%	2172
Байр, сүүч болон хоол үйнсээр үйл ажиллагаа	4.1%	1580	4.9%	121	2.6%	167	0.3%	34	1.7%	111	3.2%	2012
Мэдээлэл, холбоо	1.4%	539	0.0%	0	0.1%	7	3.8%	365	1.4%	92	1.6%	1004
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.9%	1095	4.6%	114	3.0%	196	0.0%	0	1.2%	76	2.3%	1482
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.3%	119	2.7%	67	0.0%	0	10.0%	97	1.4%	88	0.6%	371
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4.9%	1887	2.9%	71	1.3%	88	2.0%	195	0.6%	42	3.6%	2283
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.8%	1060	0.5%	13	2.4%	157	4.4%	424	1.7%	112	2.8%	1766
Боловсрол	1.7%	647	0.4%	9	1.4%	94	10.0%	973	0.9%	58	2.8%	1781
Хүний эрүүл мэнд ба нийтийн үйл ажиллагаа	3.0%	1141	0.5%	13	2.3%	151	3.8%	371	0.4%	29	2.7%	1705
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2.4%	903	2.7%	68	3.0%	199	3.6%	347	1.2%	81	2.5%	1597
Үйлилгээний бусад үйл ажиллагаа	4.1%	1568	18.8%	463	22.3%	1459	4.6%	443	0.4%	27	6.2%	3960
Нийт	100%	38169	100%	2468	100%	6544	100%	9686	100%	6527	100%	63394

Хавсралт 2. Ирэх нэг жилийн сүүлийн б сарын ажиллах хүчиний эрэгт

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Улаанбаатар		Зүүн бүс		Төвийн бүс		Хангайн бүс		Баруун бүс		Нийт дүнгээр	
	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, затас барилг, ан агуулур	1.1%	81	8.2%	27	21.3%	834	13.6%	289	29.5%	801	12.1%	2032
Уул уурхай, олборлолт	1.6%	122	0.0%	0	0.9%	37	0.0%	0	4.2%	113	1.6%	272
Боловсрุулах үйлдвэрлэл	4.9%	376	0.0%	0	7.4%	288	30.1%	640	16.3%	443	10.4%	1746
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.4%	27	0.7%	2	0.6%	25	6.7%	143	0.1%	2	1.2%	201
Усан хангамж, бөхир үс, хог, хаягдлын менежмент болон цэвэрээх үйл ажиллагаа	0.3%	22	0.3%	1	0.1%	5	0.0%	1	0.2%	4	0.2%	33
Барилга	9.8%	754	0.0%	0	0.9%	34	6.3%	133	25.0%	678	9.6%	1599
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	59.3%	4546	64.6%	210	44.4%	1736	21.8%	462	3.1%	83	42.0%	7036
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.9%	72	4.6%	15	0.1%	5	0.0%	0	0.0%	0	0.5%	91
Байр, сүүч болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2.0%	153	0.0%	0	7.9%	311	0.0%	0	6.4%	173	3.8%	637
Мэдээлэл, холбоо	1.7%	128	16.1%	52	0.0%	0	0.0%	0	1.6%	45	1.3%	225
Санхүүгийн болон даяаталын үйл ажиллагаа	0.3%	25	0.0%	0	0.0%	0	0.0%	0	0.0%	0	0.1%	25
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4%	30	0.0%	0	0.0%	0	0.0%	0	0.0%	0	0.2%	30
Мэргэжлийн, шинжлэх үзүүлэл болон техникийн үйл ажиллагаа	4.2%	319	4.3%	14	0.0%	0	2.5%	53	2.8%	76	2.8%	461
Захиргааны болон дээжлагт /зүүлэх үйл ажиллагаа	5.2%	397	0.0%	0	4.1%	160	0.0%	0	1.9%	53	3.6%	610
Боловсрол	4.0%	304	0.0%	0	7.9%	309	18.8%	400	0.0%	0	6.1%	1013
Хүний эрүүл мэнд ба нийтмийн үйл ажиллагаа	0.8%	63	1.2%	4	0.3%	11	0.0%	0	0.1%	2	0.5%	79
Урлаг, үзвэр, тоглоом наадам	2.3%	174	0.0%	0	3.4%	131	0.2%	4	0.4%	10	1.9%	320
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.9%	72	0.0%	0	0.7%	28	0.0%	0	8.5%	230	2.0%	329
Нийт	100%	7666	100%	324	100%	3914	100%	2124	100%	2712	100%	16740

Хавсралт 3. Ирэх нэг жилийн ажиллах хүчиний эрэлт

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт хөргөлтээг ажиллах хүч	Улаанбаатар		Зүүн бүс		Төвийн бүс		Хангайн бүс		Баруун бүс		Нийт дунгэр	
		хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас баирлалт, ан агнуур	7475	2.5%	1138	20.6%	577	19.9%	2076	13.9%	1637	22.2%	2047	9.3%	7475
Уул уурхай, олборлолт	1705	2.1%	948	2.0%	55	0.4%	42	0.2%	21	6.9%	638	2.1%	1705
Боловсруулах, үйлдвэрлэл	9134	9.7%	4456	9.0%	250	11.5%	1199	14.1%	1661	17.0%	1568	11.4%	9134
Цахилгаан, хий, уур-, агааржуулалтын хангамж	1710	0.2%	85	11.1%	311	0.5%	50	5.4%	641	6.8%	624	2.1%	1710
Усан хангамж; бохир УС, хот, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	173	0.1%	66	0.1%	2	0.3%	29	0.6%	72	0.0%	4	0.2%	173
Барилга	11442	18.4%	8444	10.5%	292	4.8%	505	2.8%	329	20.3%	1872	14.3%	11442
